



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг,
Утас/Факс: (976)-7036-3653

2016.05.03 № 160
танай _____-ны № _____-т

Хэлэлцүүлэг зохион байгуулах тухай

УИХ-аас 2015 онд баталж 2016 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөж байгаа Ойн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуульд "Ойгоос мод бэлтгэх журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэж заасны дагуу БОНХАЖЯ-наас уг журмын төслийг боловсруулан ирүүлжээ.


Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-ын 2.3.6-д заасныг үндэслэн уг журмын төслийг орон нутгаас санал авахаар хүргүүлж байна.

Иймд бүс нутгийнхаа хэмжээнд иргэд, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, ойн мэргэжлийн байгууллага зэргийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан журмын төсөлд тусгах саналыг хэлэлцүүлэг явуулсан тухай тайлан, холбогдох материалын хамт 5 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Журмын төслийг www.selenge.env.mn хаягаар болон Ойн анги, байгаль хамгаалагчдын сүлжээгээр орж танилцаж болно.

Хавсралт 7-хуудас.

ДАРГА



Б.БАТЗОРИГ